



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 10/02

Хөхбүрд

Г Санал хүргүүлэх тухай Г


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дах заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын аравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргаас ирүүлсэн “Санал авах тухай” 2023 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн 2/383 тоот албан бичигт дурдсан, сумын нутаг дэвсгэрт хамаарах талбайд, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох боломжтой эсэхийг хэлэлцээд, заагдсан газар нутаг нь ойн сан, усан сан, мал аж ахуйн бэлчээрийн бүс, малчдын өвөлжөө, хаваржааны бүс нутгийг хамарч байгаа тул сумд хамаарах нийт талбайд сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсугай.

2. Сонгон шалгаруулалтад хамрагдсан газар нутгийн экологийн мэдээ, судалгааг гаргаж, холбогдох газарт хүргүүлэхийг сумын Засаг дарга (Ж.Хатанбаатар)-т даалгасугай

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороо (С.Энх-Амгалан)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ОТГОНБАЯР

648801053